



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/519

Улаанбаатар хот

Бусад эх үүсвэрээс санхүүжих зээл,  
тэтгэлгийн хяналтын тоог батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Тусгай сангийн тухай хуулийн 8.3 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Багш, багш мэргэжлээр суралцах болон багш, ажилтны хүүхдийг тэтгүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, мөн Боловсролын сайдын 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн А/363 тоот "Хяналтын тоо батлах тухай" тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад бусад эх үүсвэрээс санхүүжих зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж олгох 2025 оны хяналтын тоог нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан хяналтын тоог баримтлан хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгох, цаашид хяналтын тооны ашиглалтын талаарх мэдээллийг 2025 оны 12 дугаар сард багтаан танилцуулахыг Боловсролын зээлийн сан (О.Сийлэгмаа)-д даалгасугай.

3.Энэхүү тушаалыг хэрэгжилтийг удирдан зохион байгуулалтаар хангаж, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Дээд болон мэргэжлийн боловсролын бодлого зохицуулалтын газар, Санхүү хөрөнгө оруулалтын газарт тус тус даалгасугай.

САЙД

П.НАРАНБАЯР



14351 1436

Боловсролын сайдын 2025 оны 10...  
дугаар сарын 29-ны өдрийн А/519 тоот  
тушаалын Нэгдүгээр хавсралт



ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧДАД  
БУСАД ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ ЗЭЭЛ, ТЭТГЭЛЭГ,  
БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ 2025 ОНЫ ХЯНАЛТЫН ТОО

| Д/д | Хөтөлбөр                                                                      | Хяналтын тоо<br>(хүртэлх) |
|-----|-------------------------------------------------------------------------------|---------------------------|
| 1   | Зарим эрэлттэй мэргэжлээр суралцагч                                           | 500                       |
| 2   | Зорилтод бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламж                          | 10                        |
| 2   | Сургалтын төлбөрийн буцалтгүй /багш ажилтны 1 хүүхэд                          | 730                       |
| 3   | Багш мэргэжлээр суралцаж буй оюутны тэтгэлэг                                  | 2500                      |
| 4   | Засгийн газрын тэтгэлэг /дотоод/                                              | 550                       |
| 5   | Орон нутгийн их, дээд сургуульд суралцагчийн сургалтын<br>төлбөрийн хөнгөлөлт | 800                       |
| 6   | Сургалтын төлбөрийн зээл /дотоод/                                             | 500                       |
|     | Нийт                                                                          | 5590                      |

---o0o---